



БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ: ТӨВ, СЭЛЭНГЭ, ДУНДГОВЬ АЙМАГТ

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо ТББ нь 2020 онд ННФ-ын дэмжлэгтэйгээр бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээний хэрэгжилтэд мониторинг хийв. Мониторингийн хүрээнд Төв аймгийн Заамар, Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө, Баянгол, Орхонтуул сумд, Түнхэл, Хэрх, Бугант тосгон, Дундговь аймгийн Хулд, Өлзийт, Луус, Баянжаргалан сумдад 2017-2020 онд байгуулагдсан бичил уурхайн 27 гэрээг сонгон авч хэрэгжилтийг үнэллээ. Тэрчлэн Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” орон нутагт хэрхэн хэрэгжиж байгааг давхар үнэллээ.

Мониторингийн үр дүнд Бичил уурхайгаар ашигт малтмал ашиглах журам, гэрээтэй холбоотой орон нутагт гарч буй нийтлэг зөрчлүүдийг тодорхойлж, түүнийг арилгах талаар зөвлөмж боловсруулан мониторингод хамрагдсан орон нутгийн удирдлага, бичил уурхайн байгууллагуудад хүргүүллээ. Түүнчлэн Бичил уурхайгаар Ашигт малтмал олборлох тухай журмыг орон нутгийн бодит шаардлагад нийцүүлэн сайжруулахад чиглэсэн зөвлөмж боловсруулж, холбогдох талуудад хүргүүлээд байна.

МОНИТОРИНГИЙН ДҮН

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМАНД:

- Сэлэнгэ аймгийн Мандал суманд Дууш мандал хайрхан холбоо, Баатар вангийн хишиг холбоо, Хэрх ноён хайрхан, Мандал төгөл гэсэн 4 бичил уурхайн төрийн бус байгууллага, Иргэний хуулийн 35.1-ийн дагуу байгуулагдсан Шижир хишиг нөхөрлөлийн үйл ажиллагаатай танилцаж, гэрээний хэрэгжилтэд мониторинг хийлээ.
- Тус суманд 2017-2020 онд АМГТГ-аас нийт 50,07 га талбайг хамарсан 10 газрыг бичил уурхайн зориулалтаар ашиглуулах дүгнэлт гаргажээ. Энэ хугацаанд орон нутгийн удирдлага бичил уурхайн үйл ажиллагаа явуулах 56 хүсэлт хүлээн авсны дагуу гэрээ байгуулагдаж, түүнээс 40 нөхөрлөл нь үйл ажиллагаагаа хэвийн явуулжээ. 4 нөхөрлөл гэрээний хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй байна.
- 2019 онд Засгийн газраас “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол гаргаж, бичил уурхайн үйл ажиллагааг түр хязгаарласан билээ.¹ Гэтэл Мандал сум нь 2020 онд 11 хүсэлт хүлээн авч, 9 гэрээ байгуулсан нь Засгийн газрын дээрх шийдвэртэй зөрчилдөж байна.
- Мониторингийн хүрээнд Мандал суманд 2017-2020 онд байгуулагдсан 11 гэрээг сонгон авч үнэлэхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:
 - 10 гэрээний хувьд Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээний загварыг хэвлэн холбогдох тоон хэмжүүрийг нөхөж бичилгүйгээр шууд ашиглажээ. Тухайлбал Шижир хишиг

¹ Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 355-р тогтоол

нөхөрлөлийн 2017 оны, Манлай мандал нөхөрлөлийн 2018 оны гэрээнүүдэд бичил уурхайн зориулалтаар ашиглах газрын хэмжээ, нөхөн сэргээлтэд шаардагдах мөнгөн дүн огт бичигдээгүй байна.

- Шижир оргил, Тайж ноёд нөхөрлөлтэй байгуулсан 2020 оны гэрээний Ерөнхий зүйл хугацааг 1 жил гэсэн боловч гэрээний хүчин төгөлдөр болох хэсэг буюу 6.1-д 4 сар 15 хоног гэсэн хугацаа тавьсан нь хоорондоо зөрчилдөж байна.
- Дууш мандал хайрхан холбоо ТББ нь 2020 онд 6 нөхөрлөлийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж зөрчил бүхий 2 нөхөрлөлд шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгуулжээ.
- Нутгийн захиргааны дотоод хяналт, шалгалтыг тогтмол зохион байгуулж, зөрчил гаргасан нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоох, мөнгөн торгууль оногдуулах арга хэмжээг авч ажилласан байна. Энэ хүрээнд 2020 онд сумын байгаль орчны улсын байцаагчийн дүгнэлтээр 14 зөрчил илрүүлж, арга хэмжээ авсны 4 нь Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж байгаа нөхөрлөлүүдтэй холбоотой бол 10 зөрчил нь хууль бус олборлолт буюу гаднын, бүртгэлгүй хувиараа ашигт малтмал олборлогч (ХАМО) иргэдтэй холбоотой байв.
- Орон нутгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүд нь зөвшөөрөгдөөгүй талбайд олборлолт явуулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм (ХАБЭА) зөрчсөн, хууль бусаар тээсэлгээний материал ашигласан, олборлолтын талбайд нөхөрлөлийн гишүүн бус хүн ажиллуулсан гэх мэт зөрчлүүд байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН БУГАНТ ТОСГОНД:

- Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Бугант тосгонд бичил уурхайн чиглэлээр Ерөө баян хишиг, Баян ундарга их сан, Баян Сэлэнгэ ундарга гэсэн 3 төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа явуулдаг байна.
- 2017-2020 онд АМГТГ-аас тухайн орон нутагт 13 газар буюу нийт 44.46 га талбайд бичил уурхайн дүгнэлт гаргажээ. Харин орон нутаг бичил уурхайн гэрээ байгуулах 179 хүсэлт хүлээн авснаас 97 гэрээ байгуулжээ. Гэрээний дагуу 93 нөхөрлөл үйл ажиллагаа явуулснаас мониторингийн хүрээнд санамсаргүй түүврийн аргаар 7 гэрээг сонгон авч үнэлгээ хийв. Үүнд дараах зөрчлийг олж тогтоолоо:

- 2020 онд ЗДТГ нийт 83 хүсэлт хүлээн авч, ажлын хэсэг томилон хүсэлтүүдийг эрэмбэлэн шалгаж, зохих шалгуур хангасан эхний 10 нөхөрлөлтэй гэрээ байгуулжээ. Энэхүү бичил уурхайн 10 гэрээ шинээр байгуулсан нь мөн л Засгийн газрын 2019 оны 355 дугаар тогтоолыг зөрчиж байна.
- Тэрчлэн гэрээгээр олгогдсон талбайг бусдад шилжүүлэхгүй байх тухай журмын заалтыг² зөрчсөн нэг тохиолдол гарчээ. Тухайлбал, Ерөө өгөөмөр хайрхан нөхөрлөл нь 2020 оны 7 дугаар сарын 28-ны өдөр №8 тоот гэрээг сумын Засаг даргын орлогчтой байгуулснаар Буурагчин багийн Харгана-2 нэртэй газар 2.38 га талбайд бичил уурхайн үйл ажиллагаа явуулах эрхтэй болжээ. Ерөө өгөөмөр хайрхан нөхөрлөл нь уг гэрээгээ үндэслэн Ерөө хангайтаны хишиг нөхөрлөлтэй давхар гэрээ байгуулсан байна. Энэ нь гэрээт талбайгаа бусдад шилжүүлэхгүй байх үүргийг зөрчсөн хэрэг юм. Тэрчлэн уг 2 нөхөрлөл нь зөвхөн гэрээт талбайд үйл ажиллагаа явуулах нөхцөлийг мөн зөрчиж, Харгана-2 нэртэй талбайн гадна олборлолт хийсэн байна.
- Нөхөрлөлүүдийн гаргаж буй нийтлэг зөрчлүүдийг дурдвал, гишүүн бус хүнийг талбайд ажиллуулсан,³ техник тоног төхөөрөмжийн хэмжээг хэтрүүлэн ашигласан,⁴ нөхөн сэргээлтийн төлөвлөгөөгүй ажилласан, аюулгүй байдлын дүрэм баримтлаагүй гэх мэт.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМАНД:

- Сэлэнгэ аймгийн Орхонтуул суманд Орхонтуулын хишиг ТББ үйл ажиллагаа явуулдаг байна. Хамран судалж буй 2017-2020 онд АМГТГ-аас тус суманд 5 газар буюу 15.59 га талбайд бичил уурхайн дүгнэлт гаргасан ба уг талбайд 6 нөхөрлөл

² Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээний 3.2.3 дахь заалт "гэрээгээр олгосон талбайг бусдад шилжүүлэхгүй, барьцаалахгүй, худалдахгүй, түрээслэхгүй байх"

³ Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээний 3.1.4 дэх заалт "гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг ажиллуулахгүй байх"

⁴ Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээний 3.1.10 дахь заалт "Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см³ хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах"

хүсэлт гаргаж, Засаг даргатай гэрээ байгуулж ажиллажээ. Мониторингод 2020 оны сунгалт хийсэн 1 гэрээг сонгон авсан ба тухайн гэрээтэй холбоотой ямар нэг зөрчил ажиглагдсангүй.

- Бичил уурхайн гэрээний хэрэгжилтийг хангуулах, хууль бус зөрчлийг илрүүлэх зорилгоор аймаг, сумын Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны газар, сумын Засаг дарга, байгаль орчны улсын хяналтын байцаагч, байгаль хамгаалагч, Орхонтуулын хишиг ТББ-ууд хамтарсан хяналт шалгалт хийж 2019 онд 1 нөхөрлөлийн гэрээг цуцалжээ. Техникийн шаардлага хэтрүүлсэн буюу Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 3.1.4 дэх заалтыг зөрчсөн үндэслэлээр тийнхүү гэрээ цуцлагдсан байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМАНД:

- Сэлэнгэ аймгийн Баянгол суманд Хараа нутгийн ажилгүйдлийн холбоо, Баялаг баруун хараа ТББ-ууд бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.
- 2017-2020 онд орон нутгийн захиргаа бичил уурхай эрхлэх 13 хүсэлт хүлээн авч, 13 гэрээ байгуулжээ. Гэрээ байгуулсан 13 нөхөрлөлөөс 7 нь үйл ажиллагаа явуулснаас 2 нь тогтоосон талбайн гадна үйл ажиллагаа явуулах,⁵ техникийн шаардлага хэтрүүлэх⁶ зэрэг зөрчил гаргасны улмаас гэрээгээ цуцлуулжээ.
- Сонгон авсан гэрээнүүдтэй танилцахад сумын Засаг даргын зүгээс Хараагийн шижир нөхөрлөлтэй 2019 онд гэрээ байгуулахдаа хяналтын хуудас ашигласан нь бусад орон нутагт туршлага болохуйц сайн жишиг байлаа. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох аж ахуйн нэгжүүдийн баримт бичгийн бүрдлийг хянан бүртгэх хуудас ашиглан олборлолт явуулах талбайн нэр,

⁵ Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээний 1.1 дэх заалт “Бичил уурхай эрхлэгч этгээд нь ... сум (дүүрэг)-ын ... нэртэй газарт орших ... гектар талбайд журмын 6.1.3-т заасны дагуу... жилийн хугацаатайгаар ... (ашигт малтмалын төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхэлнэ” болон 2.1.1 дэх заалт “Бичил уурхай эрхлэгч этгээдэд ноогдох талбайн хэмжээг тогтоож, байршлын зургийг гэрээнд хавсаргах”

⁶ Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээний 3.1.10 дахь заалт “Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см³ хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах”

солбицлын дүгнэлт гарсан эсэх, олборлолт явуулах талбайн байршлыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, ус ашиглах тухай гэрээг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Татвар, төлбөр хураамжийн төлөлтийг Татварын хэлтэс шалган баталгаажуулсан бол гэрээний хэрэгжилтийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс тус тус хянан баталгаажуулжээ.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЛУУС СУМАНД:

- Дундговь аймгийн хэмжээнд бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ, нөхөрлөл, хоршоод хамтран “Говийн хишиг” бичил уурхай эрхлэгчдийн холбоог үүсгэн байгуулсан бөгөөд Луус суманд Иргэний хуулийн 481.1-д заасан бүртгэгдээгүй нөхөрлөл 20, мөн хуулийн 35.1-д заасан бүртгэлтэй 9 нөхөрлөл тус холбоонд гишүүнчлэлтэйгээр хамтран ажиллаж байна.
- 2017-2020 онд бичил уурхайн зориулалтаар 20.34 га газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч дүгнэлт гаргуулжээ. 2018 онд 9 нөхөрлөлийн хүсэлтийг хүлээн авч гэрээ байгуулсан ба тэдгээр гэрээний хугацаа 2019 оны 5 дугаар сард дуусгавар болж дахин сунгагдаагүй байна.
- Харин Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан газар ашиглах хугацаа дууссан тул өмнө нь ашиглаж байсан талбайн хаягдал шороог (бага хэмжээний жоншны агуулгатай) худалдаалах, нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгөхөөр 4 нөхөрлөл ажиллаж байв. Эдгээр нөхөрлөл олборлолтын гэрээгүй бөгөөд аймгаас зохион байгуулсны дагуу 4 компанитай жонш худалдах, худалдан авах гэрээ байгуулан ажиллаж байна.
- Тус суманд олборлолтын талбайн гадна үйл ажиллагаа явуулах, техник тоног төхөөрөмжийн заасан хэмжээг хэтрүүлсэн зөрчлүүд удаа дараа гарч байжээ.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХУЛД СУМАНД:

- Тус суманд бичил уурхайчид Тахилгат лусын булаг ТББ дор нэгдэн үйл ажиллагаа явуулдаг, аймгийн нэгдсэн холбоондоо гишүүнчлэлтэй байна.
- Хулд сум 2012 онд Түймэрт цагаан нэртэй газарт 117.58 га талбайг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, АМГТГ-аар дүгнэлт гаргуулжээ. Уг талбайд 2016-2019 онд жоншны олборлолт тасралтгүй явагдсан байна. Энэ хугацаанд



17 хүсэлт хүлээн авч, гэрээ байгуулагдсан нь бүгд 2019 оны 5 дугаар сард дуусгавар болжээ.

- Жонш олборлолтын үйл ажиллагаанд Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай журамд заасан техникийн хүчин чадал тохирдоггүй талаар бичил уурхайчид ярьж байв. Тиймээс жоншны олборлолтод ашиглах техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатайг санал болголоо.
- Гэрээний хэрэгжилтийг аймаг дүгнэдэг ба мэргэжлийн хяналтын газрын удаа дараагийн шалгалтаар ХАБЭА түүнтэй холбоотой гэрээний заалтыг зөрчсөн, мөн нөхөрлөлийн гишүүн бус хүнийг ажиллуулсан зэрэг зөрчлүүд нийтлэг илэрдэг байна.
- Сонгон авсан гэрээнүүдтэй танилцахад 2018 оны Баянхангай нөхөрлөлийн гэрээнд сумын Засаг даргын нэр, нөхөрлөлийн ахлагчийн нэр, ашиглах газрын хэмжээ огт бичээгүй байна. Баянхангай нөхөрлөл нь Иргэний хуулийн 481.1-д заасан бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалт хэлбэрээр ажилладаг бөгөөд олборлолт явуулахдаа техник ашиглан олборлолт явуулж гэрээний 3.1.10⁷ дахь заалтыг зөрчсөн нь илэрсэн.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМАНД:

- Тус суманд бичил уурхайн чиглэлээр Өлзийт буян хишиг ТББ үйл ажиллагаа явуулдаг. Тус ТББ нь аймгийн холбооны гишүүнчлэлтэй. 2015-2017 онд жил бүр 6-12 нөхөрлөл ажилладаг байжээ. Өлзийт сум нь Өмбүү толгой нэртэй газарт 38.52 га газрыг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан байна. Харин тус талбайг 2017 онд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж шилжүүлэн авснаар нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд оржээ. Сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлөөс бичил уурхайчдад зөвлөн туслах хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулж бичил уурхайчдыг мэдлэг мэдээллээр хангадаг. Олборлолтын талбай байхгүйгээс 2017 оноос бичил уурхайн нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулаагүй учир, мониторингод ашиглах гэрээ олдсонгүй.

⁷ Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт илүүгүй механизмыг малтмал олборлох үйл ажиллагаанд 3500см³ хүртэлх багтаамжтай дотоод шаталтад хөдөлгүүр бүхий 2-оос ашиглах.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМАНД:

- Тусгай хэрэгцээнд бичил уурхайн зориулалтаар 17.36 га газрыг авч, АМГТГ-ын дүгнэлт гаргуулжээ.
- 2017-2020 онд сумын захиргаа 27 хүсэлт хүлээн авч, 10 нөхөрлөлтэй гэрээ байгуулжээ. Гэрээний дагуу ажилласан 10 нөхөрлөлийн гэрээг огт дүгнэж байгаагүй нь анхаарал татаж байлаа. Тус суманд ажилладаг бичил уурхайн нөхөрлөлүүд Дундговь аймгаас үүрэг болгосны дагуу худалдан авалтын 4 компанитай гэрээ байгуулан ажилладаг байна. Дээрх худалдан авалтын компаниудын техникийг ашиглан олборлолт явуулдаг ба заасан хэмжээнээс илүү хүчин чадалтай байгаа нь зөрчил үүсгэж байна. Мөн аймгийн захиргаанаас худалдан авалтын компаниудыг санал болгон ажиллуулж байгаа асуудлыг цаашид гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай байна.
- Дээрх 10 нөхөрлөлийн гэрээ 2019 онд дуусгавар болсон боловч нэг нь ч нөхөн сэргээлт хийж талбайгаа хүлээлгэн өгөөгүй байна. Энэ нь гэрээний 3.1.13 дахь заалтыг зөрчсөн явдал төдийгүй ЗДТГ-ын зүгээс ч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах үүргээ зөрчиж ирснийг харуулж байна.

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМАНД:

- Тус суманд бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 11 нөхөрлөл бүртгэлтэй байна. 2012 онд 122.18 га, 2018 онд 24.11 га талбайг тус тус орон нутгийн тусгай хэрэгцээнд бичил уурхайн зориулалтаар олгох дүгнэлт гаргуулжээ.
- 2017-2020 онд нийт 11 нөхөрлөлөөс хүсэлт авч, гэрээ байгуулжээ. Тэдгээрээс 4 нөхөрлөл олборлолтоо дуусаж, нөхөн сэргээлт эхлүүлжээ. Харин Жаргалан нөхөрлөл нь Нүдэн нэртэй 5.0 га талбайд нөхөн сэргээлтээ гүйцэтгэн хүлээлгэн өгснөөр нөхөн сэргээлтийн санд байршуулсан мөнгөө буцаан авах шаардлагыг хангаад байна.
- Тус суманд ХАБЭА-ны дүрэм баримтлаагүй буюу гэрээний 3.1.6 дахь заалтыг зөрчсөн, мөн нөхөрлөлийн гишүүн бус хүнийг ажиллуулсан буюу гэрээний 3.1.4 дэх заалтыг биелүүлээгүй зөрчлүүд нийтлэг гардаг байна.

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМАНД:

- Тус суманд Тосон Заамар ундарга, Баянгол баясгалант хайрхан, Төглийн хишиг, Есөн найзууд хоршоо, Заамар нутгийн хөгжилд бидний оролцоо зэрэг бичил уурхайн байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг.
- Бичил уурхайн зориулалтаар 2018 онд 9.93 га талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан ба 2017-2020 онд нийт 195 хүсэлт хүлээн авснаас 71 нөхөрлөлтэй гэрээ байгуулжээ. Үүнээс 22 нь гуравласан гэрээ бол 49 гэрээ нь хоёр талт гэрээ байна.
- 2020 онд 72 нөхөрлөлийн хүсэлтийг хүлээн авснаас 27-той нь гэрээ байгуулсан нь Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 355 дугаар тогтоолыг зөрчсөн байна. Эдгээрээс 3 нөхөрлөл нь өөрийн хүсэлтээр гэрээгээ цуцалжээ.
- Мониторингод ашиглах зорилгоор 2020 онд байгуулагдсан 4 гэрээг санамсаргүй түүврийн аргаар сонгон авсан. Тус 4 гэрээний 2 нь уул уурхайн компани, сумын Засаг дарга, бичил уурхайн нөхөрлөл хооронд байгуулагдсан 3 талт гэрээ байсан бол үлдсэн 2 нь сумын Засаг дарга, бичил уурхайн нөхөрлөлийн хооронд байгуулагдсан 2020 оны 2 талт гэрээ байна.
- Заамар суманд бичил уурхайд гардаг нийтлэг зөрчил нь гэрээгээр тогтоосон талбайд үйл ажиллагаа явуулдаггүй, техник тоног төхөөрөмжид тавих шаардлага хэтрүүлдэг, нөхөрлөлийн гишүүн бус иргэнийг ажиллуулдаг зэрэг байна. Тухайлбал, Эрдэнэ-Очир, Нутгийн хишиг бүртгэгдээгүй нөхөрлөлүүд 2020 онд байгуулсан гэрээний хүрээнд ажиллахдаа Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай журмын 3.1.10 дахь заалтыг зөрчин техник ашиглаж олборлолт явуулжээ.

МОНИТОРИНГИЙН ДҮГНЭЛТ

- Журмын 3.2.2 дахь заалт дараах байдлаар зөрчигдөж байна. Үүнд:
 - Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох өргөдөлд “Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө”-г хавсаргадаггүй. Нутгийн захиргааны байгууллага нь баримт бичгийн бүрдэл дутуу байгааг үл харгалзан бичил бичил уурхайн нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулдаг. Ингэснээр Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээний 3.1.11-д нөхөн сэргээлтэд шаардагдах мөнгөн дүнг тусгахгүй орхих, эсхүл таамгаар дэвшүүлэх, эцэстээ нөхөн сэргээлтийн явцад хөрөнгө дутагдах, бүр нөхөн сэргээлт хийгдэхгүй үлдэхэд хүргэж байна.
 - Тэрчлэн нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн мөнгийг буцаан авах, олгох тохиолдол маш ховор байна.⁸ Энэ нь нөхөн сэргээлтийн зардлыг бодитой тооцдоггүйтэй холбоотой.
- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээний 3.1.4 дэх заалтыг зөрчин нөхөрлөлийн гишүүн бус хүнийг ажиллуулах, Журмын 3.1.10 дахь заалтыг зөрчин журамд зааснаас илүү хүчин чадалтай, том оврын машин техник ашиглах зөрчил бүх сумдад нийтлэг байна. Энэ нь үйлдвэрлэлийн аргаар өмнө нь ашиглаж байсан, их хэмжээний эвдрэлтэй талбайд үйл ажиллагаа явуулахад журамд заасан техникийн хүчин чадал хүрэлцдэггүйтэй холбоотой. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн Ерөө, Орхонтуул сумд дахь алтны ил уурхай, Дундговь аймгийн жоншны бичил уурхайд энэ зөрчил илүү түгээмэл байна.
- Бичил уурхай эрхлэгч нь Иргэний хуульд заасан бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг бол ямар нэг техник ашиглах эрхгүй байдаг. Гэтэл мониторингод Төв аймгийн Заамар, Дундговь аймгийн Баянжаргалан сумдад бүртгэлгүй нөхөрлөлүүд машин техник ашиглан олборлолт явуулж байна.
- Өөрийн техник хэрэгсэлгүй тохиолдолд нөхөрлөлүүд техник түрээсэлж, жолоочийн хамт ажиллуулдаг нь гэрээний 3.1.4 дэх заалт⁹ зөрчигдөхөд хүргэж байна.
- Дундговь аймаг, Сэлэнгэ аймагт гэрээний загварыг шууд хэвлэж, гараар бөглөн ашиглахдаа нөхөн сэргээлтийн зардлын дүн гэх мэт хоёр тал тохиролцон тусгадаг заалт,

⁸ Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээний 3.1.12 дахь заалт “Нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах”

⁹ Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээний 3.1.4 гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг ажиллуулахгүй байх;

тоон хэмжигдэхүүнүүдийг бөглөхгүй орхих, эсхүл гаргацгүй бичих дутагдал нийтлэг байна. Энэ нь гэрээний хэрэгжилтийг хянах, дүгнэх боломжгүй болгох бөгөөд гэрээнийхээ хэрэгжилтийг дүгнэдэггүй дутагдал дээрх 2 аймагт байсаар байна.

- Олборлолтын талбайн гадна буюу гэрээгээр тогтоосноос өөр газарт олборлолт явуулсан зөрчил¹⁰ орон нутгуудад мөн түгээмэл байна. Ашигт малтмалын тухай хуульд зааснаар бичил уурхайн үйл ажиллагааг зөвхөн үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй, эсхүл ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд л явуулах ёстой. Гэтэл орон нутаг өмнө нь хөндөгдөөгүй эрүүл газрыг, эсхүл бичил уурхайгаар олборлолт явуулах

¹⁰ Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээний 1.1 дэх заалт “Бичил уурхай эрхлэгч этгээд нь ... сум (дүүрэг)-ийн ... нэртэй газарт орших ... гектар талбайд журмын 6.1.3-т заасны дагуу ... жилийн хугацаатайгаар ... (ашигт малтмалын төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхэлнэ.”, мөн 2.1.1 дэх заалт “Бичил уурхай эрхлэгч этгээдэд ноогдох талбайн хэмжээг тогтоож, байршлын зургийг гэрээнд хавсаргах”

боломжгүй газруудыг тусгай хэрэгцээнд авч, нөхөрлөлүүдэд олгодог нь дээрх зөрчлийн гол шалтгаан болж байна. Энэ нь газар нутгийг бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авах шийдвэрийг аймгийн ИТХ буюу сум, орон нутгийн газар нутаг, онцлогийг мэддэггүй хүмүүс гаргадагтай холбоотой юм.

- Гэрээт талбайг бусдад дамжуулан түрээсэлсэн буюу журмын 3.2.3 дахь заалтыг зөрчсөн тохиолдол Сэлэнгэ аймгийн Ерөө суманд гарсан байна.
- 2019 онд Засгийн газраас тогтоосон шинээр гэрээ байгуулахгүй байх¹¹ хоригийг зөрчин 2020 онд бичил уурхайн гэрээ шинээр байгуулсан зөрчил Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө, Төв аймгийн Заамар сумдад гарсан байгаа нь төр засгийн шийдвэр орон нутгийн түвшинд өөр өөр ойлголтоор хүрч бүрэн хэрэгжихгүй байгааг харуулж байна.

¹¹ МУ-ын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 355 дугаар тогтоол: 1.1 дэх заалт шинээр гэрээ байгуулахгүй байх.

МОНИТОРИНГИЙН ЗӨВЛӨМЖ

1. Нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн иргэд болон бичил уурхай эрхлэгчдийн хууль тогтоомжийн талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх;
2. Нутгийн захиргааны байгууллагууд бичил уурхайн гэрээ байгуулахдаа хариуцлагатай хандаж, баримт бичгийн бүрдэл, гэрээний агуулгыг бүрэн тодорхойлоход анхаарах;
3. Нутгийн захиргааны болон мэргэжлийн хяналтын байгууллагууд бичил уурхайн журам, гэрээний хэрэгжилтэд тавих хяналтаа сайжруулж, зөрчлийг арилган, шалтгаан нөхцөлийг тодорхойлж холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлж байх;
4. Гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэн, зөрчил гаргасан нөхөрлөлтэй дахин гэрээ байгуулахгүй байх замаар бичил уурхай эрхлэгчдийн хариуцлагыг нэмэгдүүлэх;
5. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг шинэчлэх. Үүнд: орон нутгийн геологийн нөхцөл байдал, эрдсийн төрлийн онцлогоос хамаарч техникийн хүчин чадлыг тодорхойлох, газар нутгийг бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авах шийдвэрийг сумын ИТХ гаргадаг болох;
6. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан 2017 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн А/115, А/123 дугаар тушаалыг хэрэгжүүлэх;
7. БОАЖ-ын, УУХҮ-ийн сайдуудын хамтарсан 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн А/226, А/182 дугаар тушаалыг хэрэгжүүлэх;
8. Орон нутагт явагдаж байгаа бичил уурхайн үйл ажиллагаа, гэрээний мэдээллийн ил тод байдлыг сайжруулах замаар олон нийтийн хяналтыг бий болгох;
9. Тэсэлгээний ажилд тавих хяналтыг сайжруулах, тэсэлгээний тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх зохицуулалтыг эргэн харах;
10. Хоргүй технологиор хүдэр боловсруулах цэгийг сумаас тогтоож өгөх, химийн хорт бодисын далд хэрэглээг арилгах.